



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Цаг хугацааны хуваарь батлах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулах цаг хугацааны хуваарь”-ийг хавсралтаар баталсугай.

2.Цаг хугацааны хуваарийг холбогдох этгээдэд хүргүүлэх, нийтэд мэдээлэх ажлыг Ажлын албаны дарга /Д.Баяндүүрэн/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д тус тус даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000006

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 28 ДУГААР ТОЙРОГТ ЯВАГДАХ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ НӨХӨН СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЦАГ ХУГАЦААНЫ ХУВААРЬ**

№	Хийгдэх ажил	Хуулийн заалт	Хуанлийн хугацаа
Нэг.СОНГУУЛИЙН ТОЙРОГ, ХЭСЭГ			
1	Сонгууль товлон зарлах, санал авах өдөр тогтоох	Улсын Их Хурал нөхөн сонгуулийг санал авах өдрийн хамт санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө нөхөн сонгууль явуулах нөхцөл байдал үүссэнээс хойш 50 хоногийн дотор энэ хуульд нийцүүлэн товлон зарлана. (Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг) (Улсын Их Хурлын 2020 оны 40 дүгээр тогтоол)	2020.12.12-ноос өмнө
2	Сонгуулийн хэсэг байгуулах	Сонгогчдын санал авч, тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог үндэслэн хэсгийг нөхөн сонгууль товлон зарласнаас хойш 20 хоногийн дотор байгуулж , хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарлана. Ээлжит сонгуулиар байгуулагдсан хэсгийг энэ хуульд зааснаас бусад тохиолдолд дараагийн ээлжит сонгууль хүртэл өөрчлөхгүй. (Хуулийн 13 дугаар зүйлийн 13.10, 21.1 дэх хэсэг)	2020.12.30-наас өмнө
3	Сонгуулийн хэсгийн талаарх мэдээллийг хүргүүлэх	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид сонгуулийн хэсгийг байгуулсан өдрөөс хойш тав хоногийн дотор энэ хуулийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлнэ. (Хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг)	2021.01.03-ны дотор
		Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс энэ хуулийн 13.6-д заасан мэдээллийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нэгтгэн тав хоногийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. (Хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг)	2021.01.08-ны дотор
Хоёр.СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА			
4	Сонгуулийн байгууллагын удирдлага	Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн ерөнхий хороо удирдан зохион байгуулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн болон хэсгийн хороог нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана. (Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг)	Сонгуулийн үйл ажиллагааны туршид
5	Аймаг, нийслэлийн сонгуулийн хороог байгуулах	Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан дарга, нарийн бичгийн дарга болон тав, эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ. (Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг)	2021.3.31-нээс өмнө

6	Сум, дүүргийн сонгуулийн хороог байгуулах	Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хороог санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан дарга, нарийн бичгийн дарга болон гурав, эсхүл таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ. (Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг)	2021.4.10-наас өмнө
7	Хэсгийн хороог байгуулах	Сум, дүүргийн сонгуулийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга болон зургаа, эсхүл найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ. (Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг)	2021.4.25-наас өмнө
Гурав.СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ			
8	Иргэний шилжилт, хөдөлгөөнийг зогсоох	Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг нөхөн сонгууль явуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол уг шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн өдрийн дараах ажлын өдрөөс эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ. (Хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгээс)	Тогтоол хүлээн авсны дараах ажлын өдрөөс зогсоож 2021.6.10-наас сэргээнэ.
9	Сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хуудаст байршуулах	Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтыг нөхөн сонгууль товлон зарласнаас хойш 50 хоногийн дараагаас эхлэн сонгууль дуустал өөрийн цахим хуудаст байршуулна. (Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг)	2021.1.30-наас эхлэн
10	Эрх бүхий байгууллагууд сонгуулийн насны иргэдийн мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлэх	Энэ хуулийн 20.6-д заасан байгууллага холбогдох мэдээллийг санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.: - эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон сонгуулийн насны иргэдийн мэдээллийг Улсын дээд шүүх; - хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан, захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа болон зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага; - 60 түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэдийн мэдээллийг Улсын хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага; - тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр харьяа тусгай анги, салбарт нь алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг Улсын хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага; - тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр зэвсэгт хүчний цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; - тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч тухайн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч, дотоодын цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг цагдаагийн төв байгууллага; - зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг цагдаагийн төв байгууллага; - тухайн жилд Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, харьяатаас гарсан иргэдийн мэдээллийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага. (Хуулийн 20 дугаар зүйлийн 20.6, 21.3 дахь хэсэг)	2021.4.30-наас өмнө
11	Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хороонд хүргүүлэх	Энэ хуулийн 21.5-д заасны дагуу өөрчлөлтийг тусгасан сонгогчдын нэрийн жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр	2021.5.25-наас өмнө

		<p>дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - сонгогчоос энэ хуулийн 20.4-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн талаар гаргасан гомдлын дагуу оруулсан өөрчлөлт; - энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан хугацаанаас өмнө хийгдсэн сонгогчийн байнга оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт; - сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс, регистрийн дугаар зэрэг иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт; - нас барсан иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт; - энэ хуулийн 20.6-д заасан иргэдийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлт. <p>(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.9, 21.5, 21.6 дэх хэсэг)</p>	
12	Сонгогч нэрийн жагсаалтын мэдээлэлтэй танилцах	<p>Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, өөрийн ажиллах байргүй бол сум, хорооны Засаг даргын Тамгын газрын байранд сонгогч өөрт нь холбогдох мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломж олгоно.</p> <p>(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсэг)</p>	Хүлээн авсан өдрөөс эхлэн
13	Сонгогч нэрийн жагсаалтад бүртгэлтэй эсэхээ шалгах, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол гаргах	<p>Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шалгасан байвал зохино.</p> <p>(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсэг)</p> <p>Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад дахь өөрийн болон гэр бүлийн гишүүний мэдээлэлтэй танилцах эрхтэй бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн бол өөрийн болон гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.</p> <p>(Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг)</p>	2021.5.26-наас өмнө
14	Сонгогчийн шилжилт	<p>Сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байгаа цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шийдвэрлэнэ.</p> <p>(Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг)</p> <p>Нэр дэвшигч болон энэ хуулийн 37.3-т заасан менежер, шадар туслагч нь сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих бол санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг хийлгэж болно.</p> <p>(Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг)</p> <p>Энэ хуулийн 24.1, 24.2-т заасан сонгогч санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг бүртгүүлнэ.</p> <p>(Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг)</p>	2021.5.26-наас өмнө
15	Сонгогчийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлтийг тусгах	<p>Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг үндэслэн энэ хуулийн 23.1-д заасны дагуу гомдол гаргасан иргэний мэдээллийн талаар лавлагаа гаргах ба сонгогчийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө сонгогчдын нэрийн жагсаалтад оруулна.</p> <p>(Хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг)</p>	2021.6.6-наас өмнө
Дөрөв.НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ			
16	Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх	<p>Нам, эвсэл Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, сонгуульд оролцох тухай хүсэлтээ санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.</p> <p>(Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг)</p>	2021.4.10-наас өмнө

17	Нам эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах	Сонгуулийн ерөнхий хороо сонгуульд оролцох тухай нам, эвслийн баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногт багтаан сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана. (Хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг)	2021.4.14-ний дотор
18	Нэр дэвшүүлэх ажиллагаа	Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана. (Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг)	2021.4.25-наас 2021.5.01-нийг дуустал
		Бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана. (Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг)	
19	Нэр дэвшигчид хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлэх	Нэр дэвшигч энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссанаас хойш гурав хоногт багтаан нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт мэдүүлнэ. Авлигын эсрэг хуульд заасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргасан этгээд хамаарахгүй. (Хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэг)	2021.5.04-ний дотор
20	Хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх лавлагааг хүргүүлэх	Авлигатай тэмцэх газар нь нийт нэр дэвшигчид хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлсэн эсэх талаарх лавлагааг энэ хуулийн 32.4-т заасан хугацаа дууссанаас хойш нэг хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ. (Хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэг)	2021.5.05-ны дотор
21	Нэр дэвшигчдийн баримт бичгийг ирүүлэх	Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт багтаан... баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ: (Хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгээс)	2021.5.06-ны дотор
		Бие даан нэрээ дэвшүүлэгч нь бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт багтаан ... баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ: (Хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгээс)	
22	Нэр дэвшигчийг бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэх	Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргана. (Хуулийн 32 дугаар зүйлийн 32.11 дэх хэсэг)	Хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор
23	Нэр дэвшигчийг дахин бүртгүүлэх хүсэлт уламжлах, өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлэх	Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан тохиолдолд санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин бүртгүүлэхээр шаардагдах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлж болно. (Хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг)	2021.5.15-наас өмнө
		Дараах тохиолдолд санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлж болно: - нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан; - нэр дэвшигч нас барсан; - нэр дэвшигч шүүхээр ял шийтгүүлсэн. (Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг)	
24	Дахин бүртгүүлэх хүсэлт гаргасан, нөхөн нэр	Сонгуулийн ерөнхий хороо дахин бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч, энэ хуулийн 32.12-т заасан хугацаанаас өмнө бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. (Хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг)	2021.5.18-наас өмнө

	дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэх	Сонгуулийн ерөнхий хороо нөхөн нэр дэвшүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч, энэ хуулийн 32.12-т заасан хугацаанаас өмнө бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. (Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг)	
25	Нэр дэвшигчийн үнэмлэх олгох, нийтэд мэдээлэх	Нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарсан бол Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнө нэг өдөр олгож, нийтэд мэдээлнэ. (Хуулийн 32 дугаар зүйлийн 32.12 дахь хэсэг)	2021.5.18-ны өдөр
26	Нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг нээлттэй байршуулах	Энэ хуулийн 32.12-т заасны дагуу нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлэн Авлигатай тэмцэх газар нэр дэвшигчээр бүртгэгдсэн нийт нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг өөрийн байгууллагын цахим мэдээллийн сүлжээнд нээлттэйгээр байршуулна. (Хуулийн 32 дугаар зүйлийн 32.15 дахь хэсэг)	2021.5.18-наас эхлэн
Тав.СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, СУРТАЛЧИЛГАА			
27	Нам, эвсэл мөрийн хөтөлбөр болон хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар хүргүүлэх	Нөхөн сонгуулиар нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөр болон энэ хуулийн 26.3.6, 26.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ. (Хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг)	2021.3.25-наас өмнө
28	Бие даан нэр дэвшигч мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар хүргүүлэх		2021.5.01-нээс өмнө
29	Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргуулахаар дахин хүргүүлэх	Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ. (Хуулийн 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсэг)	Дүгнэлт гарснаас хойш 5 хоногийн дотор
30	Нам, эвслийн мөрийн хөтөлбөрийн талаарх дүгнэлтийг хүргүүлэх	Төрийн аудитын дээд байгууллага нам, эвслийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ. (Хуулийн 38 дугаар зүйлийн 38.10 дахь хэсэг)	2021.4.10-наас өмнө
31	Ухуулах хуудас байрлуулах байршлыг тогтоож, нийтэд мэдээлэх	Ухуулах хуудас болон зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт үнэ төлбөргүйгээр байрлуулах байршлыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ. (Хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэг)	2021.4.10-наас өмнө
32	Бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийг	Төрийн аудитын дээд байгууллага нь бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 33-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.	2021.5.07-ноос өмнө

	хүргүүлэх	(Хуулийн 38 дугаар зүйлийн 38.11 дэх хэсэг)	
33	Радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлэх	Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг дараах баримт бичиг, мэдээллийн хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлж, бүртгүүлнэ: (Хуулийн 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсэг)	2021.5.10-наас өмнө
34	Сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах	Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзсэний үндсэн дээр сонгуулийн сурталчилгаа эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө батална. (Хуулийн 46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсэг)	2021.5.11-нээс өмнө
35	Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлангийн талаарх дүгнэлтийг цахим хуудаст нээлттэй байршуулах	Төрийн аудитын дээд байгууллага нь энэ хуулийн 26.3.6, 26.4.6-д заасан тайлан, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнөөс эхлэн энэ хуульд заасны дагуу нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хүргүүлэх өдрийг дуустал өөрийн байгууллагын цахим хуудаст нээлттэйгээр байршуулна. (Хуулийн 38 дугаар зүйлийн 38.12 дахь хэсэг)	2021.5.18-наас эхлэн 2021.7.24-нийг дуустал
36	Сонгуулийн сурталчилгааг эхлүүлэх, зогсоох	Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно. (Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг)	2021.5.18-наас эхлэн 2021.6.07-ныг дуустал
37	Сонгуулийн сурталчилгаа явуулах цахим хуудсыг бүртгүүлэх	Нэр дэвшигч энэ хуулийн 47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ. (Хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг)	2021.5.21-ний дотор
38	Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгаа явуулсан тайланг нийтэд мэдээлэх	Сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлнэ. (Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэг)	2021.6.17-ны дотор
Зургаа.САНАЛ АВАХ, ДҮН ГАРГАХ			
39	Санал авах өдөр, цаг, байрыг нийтэд мэдээлэх	Хэсгийн хороо нь санал авах байрын дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны зураглалыг 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ. (Хуулийн 62 дугаар зүйлийн 62.7 дахь хэсэг)	2021.5.26-наас эхлэн санал авах өдрийг дуустал
40	Санал авах байр бэлтгэх	Тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай ... зүйлийг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэгтэй: (Хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг)	2021.6.02-ноос өмнө
41	Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар	Энэ хуулийн 63.1.1, 63.1.2, 63.1.3, 63.1.4-т заасан сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ тухайн байгууллагын удирдлагад	2021.6.02-ноос өмнө

	санал өгөх хүсэлт хүргүүлэх	<p>өгөх бөгөөд байгууллагын удирдлага уг хүсэлтийг тодорхойлолтын хамт санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө өөрийн байгууллагын нутаг дэвсгэрийн хувьд харьяалагдах сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ. (Хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсэг)</p>	
		<p>Сум, дүүргийн сонгуулийн хороо энэ хуулийн 63.4-т заасны дагуу ирүүлсэн хүсэлт, тодорхойлолтыг санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө тухайн байгууллагын нутаг дэвсгэрийн хувьд харьяалагдах хэсгийн хороонд хүргүүлнэ. (Хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг)</p>	2021.6.04-нөөс өмнө
		<p>Эрүүл мэндийн байдлын улмаас зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч өөрийн эрүүл мэндийн талаарх эмчийн магадалгааг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн хамт санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө дараах байдлаар хүргүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - эмнэлэг, сувилалд хэвтэн эмчлүүлж байгаа сонгогч тухайн байгууллагын захиргаанд; - бусад тохиолдолд өөрийн харьяа хэсгийн хороонд. <p>(Хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэг)</p>	2021.6.06-наас өмнө
42	Ажиглагчаар бүртгүүлэх хүсэлтээ хүргүүлэх, бүртгүүлэх	<p>Ажиглагч томилох эрх бүхий этгээд ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу бичгээр гаргаж, санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд хүргүүлнэ. (Хуулийн 67 дугаар зүйлийн 67.7 дахь хэсэг)</p>	2021.6.04-нөөс өмнө
		<p>Хэсгийн хороо хүсэлтийг хүлээн авч нягтлан шалгаж, санал авах өдрөөс хоёроос доошгүй хоногийн өмнө ажиглагчийн үнэмлэх олгоно. (Хуулийн 67 дугаар зүйлийн 67.9 дэх хэсэг)</p>	2021.6.07-ноос өмнө
43	Саналын хуудсыг санал авах байранд хүргүүлэх	<p>Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудсыг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргүүлэх ажлыг удирдан зохион байгуулна. (Хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэг)</p>	2021.6.06-наас өмнө
44	Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах	<p>... сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар түүний хүсэлт, эмнэлгийн магадалгаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд авна: (Хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсгээс)</p>	2021.6.08-ны өдрийн 09:00-20:00 цаг
45	Санал авах өдөр, цаг	<p>Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байна. (Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг) (Улсын Их Хурлын 2020 оны 13 дугаар тогтоол) Сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07:00 цагаас 22:00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна. (Хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг)</p>	2021.6.09-ний өдрийн 07:00-22:00 цаг
46	УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг өргөн мэдүүлэх	<p>Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. (Хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4 дэх хэсэг)</p>	Санал хураалт дууссанаас хойш 15 хоногийн дотор

Долоо.СОНГУУЛИЙН ЗАРДАЛ, ТАЙЛАН			
47	Сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлэх	Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын дээд байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй. <i>(Хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсэг)</i>	2021.5.20-ноос өмнө
48	Хандив болон зардлын зарцуулалтын явцын тайланг нийтэд мэдээлэх, хүргүүлэх	Нэр дэвшигч, нам, эвсэл авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс гурав хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ. <i>(Хуулийн 58 дугаар зүйлийн 58.4 дэх хэсэг)</i>	2021.6.06-ны өдөр
49	Сонгуулийн зардлын тайланг хүргүүлэх	Нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт , нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ. <i>(Хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэг)</i>	Нам, эвсэл 2021.7.24-ний дотор Нэр дэвшигч 2021.7.09-ний дотор
50	Гүйлгээний хуулга гаргаж, аудитын байгууллагад хүргүүлэх	Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ. <i>(Хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэг)</i>	2021.7.09-ний дотор
51	Сонгуулийн зардлын тайланг хянах, нийтэд мэдээлэх	Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ. <i>(Хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэг)</i>	Нам, эвсэл 2021.9.22-ны дотор Нэр дэвшигч 2021.9.7-ны дотор

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО